



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 16 нэрийн нийт 859,462,202.15 (найман зуун тавин есөн сая дөрвөн зуун жаран хоёр мянга хоёр зуун хоёр төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 2,124,826.43 (хоёр сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун хорин зургаан төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад хөрөнгийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300743



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт

"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хүчин чадал, загвар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
Нэг. 110/10 кВ Замын-Үүд дэд станцын өргөтгөл					
1	Элегаз таслуур	LW36-126(W)/T3150-40N 126KV 3150A 40KA	72,917,176.65	243,057.23	72,674,119.40
2	Гүйдлийн трансформатор	LB6-110W3 2*100/5A	49,365,986.81	164,553.29	49,201,433.52
3	Хуурай салгуур	GW4A-126D 126KV 1250A 31.5KV	37,910,692.85	126,368.98	37,784,323.87
4	Хуурай салгуур	GW4A-126D 126KV 1250A 31.5KV	37,910,692.85	126,368.98	37,784,323.87
5	Хүчдэлийн трансформатор	TYD110/3-0.01W3	32,291,892.52	107,639.64	32,184,252.88
6	Цэнэг шавхагч	Y10W-108/281	14,476,195.00	48,253.98	14,427,941.01
Хоёр. 110/10 кВ Замын-Үүд дэд станцын хоёрдогч хэлхээний өргөтгөл					
7	10 кВ-ын гаргалгааны ячейк	1100*1200*2650,XGN2-12	62,500,437.13	208,334.79	62,292,102.34
8	110 кВ шугамын хамгаалалт, хяналтын дэлгэц	110 кВ шугамын хамгаалалт	78,125,546.41	260,418.43	77,865,127.92
		Пэритер	5,208,369.76	17,361.23	5,191,008.53
		Шитийн хэмжээ 2260x800x600mm	20,833,479.04	69,444.93	20,764,034.11
9	10 кВ хамгаалах мониторинг, хяналтын төхөөрөмжүүд	10 кВ шугамын хамгаалалт	7,812,554.64	26,041.85	7,786,512.79
10	Тоолуур	Гурван фазын дөрвөн утас, олон үйлдэлт тоолуур	1,046,882.32	3,489.61	1,043,392.71
		Гурван фазын гурван утас, олон функц тоолуур	2,609,393.25	8,697.98	2,600,695.27
Гурав. 110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцын өргөтгөл, гэрэлтүүлэг, кабель, галын хамгаалалт					
11	Гэрэлтүүлгийн шит	OPOM1R-002L003/3B32	13,796,971.50	45,989.90	13,750,981.59
12	Шит	OPOM1R-403/3B50	13,796,971.50	45,989.90	13,750,981.59
Дөрөв. 110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцын өргөтгөл хэсгийн гадна хаалт					
13	1#Хуурай салгуурын хаалт	Ф300*50, 2544mm	6,893,381.55	22,977.94	6,870,403.61
14	2#Хуурай салгуурын хаалт	Ф300*50, 5044mm	6,893,381.55	22,977.94	6,870,403.61
15	Цэнэг унтраах хаалт	Ф300*50, 2688mm	14,476,299.32	48,254.33	14,428,044.99
Тав. 110/10 кВ-ын Замын-Үүд дэд станцын өргөтгөлийн хэсэг					
16	110кВ Замын-үүд сумын дэд станцын өргөтгөлийн барилга	4500*5000mm	380,595,897.51	528,605.41	380,067,292.10
			859,462,202.15	2,124,826.43	857,337,375.72
Нийт дүн			(найман зуун тавин есөн сая дөрвөн зуун жаран хоёр мянга хоёр зуун хоёр төгрөг арван таван мөнгө)	(хоёр сая нэг зуун хорин дөрвөн мянга найман зуун хорин зургаан төгрөг дөчин гурван мөнгө)	(найман зуун тавин долоон сая гурван зуун гучин долоон мянга гурван зуун далан таван төгрөг далан хоёр мөнгө)